

## ХҮҮХДИЙГ БЭЛГИЙН МӨЛЖЛӨГТ АШИГЛАЖ БУЙ БАЙДАЛ

**А.Солонго,**  
магистр, МУИС, ЭЗС-ийн  
ХАССТ-ийн багш/судлаач

*Нийгмийн болон хувь хүний үүднээс, охид, эмэгтэйчүүдийн биеэ үнэлэх явдал нь олон талт сөрөг үр дагавартай байдаг. Өнөөдөр Монгол улсад энэ үзэгдэл зөвхөн Улаанбаатар хотод байдаг нийгмийн сөрөг үзэгдэл гэж ойлгогддог байдал өөрчлөгдөж томоохон хот суурин, хүн ам олноор оршин суудаг газруудад үндэсний хэмжээний сэтгэл эмзэглүүлсэн асуудлын нэг болоод байна.*

*Биеэ үнэлэх явдалтай хууль цагдаагийн байгууллагууд тэмцэж байгаа хэдий ч биеэ үнэлэгчдийн эсрэг авч буй арга хэмжээ, хууль тогтоомж нэмэгдэхийн хэрээр уг үзэгдэл илүү далд, нарийн зохион байгуулалтын хэлбэрт шилжиж байгааг судалгааны мэдээ, баримтууд харуулж байгаа юм. Энэхүү ажлаар, судлаач ОУХБ-ын захиалгаар МУИС-ийн ХАССТ-ийн гүйцэтгэсэн болон бусад байгууллага, судлаачдын хийсэн өсвөр насны биеэ үнэлэгч охидын талаарх судалгаануудын үр дүнг хураангуйлан уншигч та бүхэнд хүргэж байна.*

*Судалгаанд, өсвөр насны биеэ үнэлэгч охид, тэдний амьдрал, үйл ажиллагаанд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг жишээ баримттайгаар тодорхойлон гаргасан болно. Түүнчлэн судалгааны үр дүнд үндэслэн, дээрх асуудлыг шийдвэрлэх, түүнийг зохицуулах талаар төрөөс болон бусад холбогдох байгууллагуудаас явуулж буй үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандаж, бэрхшээлийг хэрхэн давж болох талаар тодорхой санал, зөвлөмжүүдийг дэвшүүлэн тавьлаа.*

Насанд хүрээгүй охидын бэлгийн харьцаанд орох төдийгүй биеэ үнэлж буй байдал өөрөө эмзэг асуудал учраас судалгаа явуулахад нэлээд хүндрэлтэй асуудалтай тулгардаг. Өмнө нь охид, эмэгтэйчүүдийн биеэ үнэлэх явдлыг зөвхөн Улаанбаатар хотод байдаг нийгмийн сөрөг үзэгдэл гэж ойлгодог байсан бол өнөөдөр томоохон хот суурин (Дархан-Уул, Орхон, Дорнод, Сэлэнгэ аймгууд, Замын-Үүд гэх мэт), хүн ам олноор оршин суудаг газруудад үндэсний хэмжээний сэтгэл эмзэглүүлсэн асуудлын нэг болоод байна. Уг асуудлыг шийдвэрлэхэд юуны өмнө биеэ үнэлж буй охид хичнээн байгаа болон тэдний нөхцөл байдал, зан чанар ямар байгааг тодорхойлох нь илүү зохимжтой гэж үзэж байна.

Үндэсний Статистикийн Газраас 1996 онд явуулсан “Хүүхэд ба Хөгжил” судалгаагаар улсын хэмжээнд нийт 46 охид биеэ үнэлдэг гэж бүртгэгдсэний 90 орчим хувь нь Улаанбаатар хотод амьдарч байна гэсэн дүгнэлт гаргасан. Харин 1999 онд Эмэгтэйчүүдийн Мэдээлэл Судалгааны Төвөөс нийт 436 биеэ үнэлэгчдийн дунд судалгаа явуулахад 79 буюу 18.1 хувь нь 10-19 насны охидууд байв. Улаанбаатар хотод байрлаж буй Хараа Хяналтгүй Хүүхдийн Төв байрны ажилтны бүртгэлд нийт 140 гаруй биеэ үнэлдэг охид бүртгэгдсэн байдаг. Цагдаагийн байгууллагад 100 орчим өсвөр насны биеэ үнэлэгч охид байна гэсэн бүртгэл байгаа боловч энэ нь зөвхөн түр саатуулагдсан эсвэл тус байгууллагад баригдаж ирсэн охидын тоо гэж болно. Гэтэл судалгааны байгууллагуудын

гаргасан тоо мэдээ үүнээс 2-3 дахин их байна. Тухайлбал, ОУХБ-ын АЙПЕК хөтөлбөрийн санхүүжилт, Монголын Хүүхэд Залуучуудын Хөгжлийн Төвийн захиалгаар МУИС-ийн Хүн Амын Сургалт Судалгааны Төвөөс 2001 онд явуулсан судалгаагаар Улаанбаатарт 200-250 охид биеэ үнэлж байна гэсэн үнэлгээ гарсан. Уг судалгаанд цагдаагийн байгууллагын ажилтнууд, охидын эмч, ЕБС-ийн сурагчид, биеэ үнэлэгч болон биеэ үнэлэх эрсдэлд байгаа охид хамрагдсан юм.

Биеэ үнэлэх явдалтай хууль цагдаагийн байгууллагууд тэмцэж байгаа хэдий ч биеэ үнэлэгчдийн эсрэг авч буй арга хэмжээ, хууль тогтоомж нэмэгдэхийн хэрээр уг үзэгдэл илүү далд, нарийн зохион байгуулалтын хэлбэрт шилжиж байгааг судалгааны мэдээ, баримтууд харуулж байна.

Өсвөр насны биеэ үнэлэгч охидуудыг тодорхой газруудад зардаг бөгөөд энэ үйл ажиллагаа *бүлэг зохион байгуулалтын* шинж чанартай болж байна. Охидыг зуучлагчид болон тэднээр үйлчлүүлэгчид хуулийн хариуцлагаас зайлсхийх үүднээс өөрсдийн үйл ажиллагааг *нуугдмал зохион байгуулалттай* хэлбэрээр явуулж байна. Түүнчлэн өсвөр насны охид өөрсдийгээ хамгаалах чадвар сул байгаа нь үүнд давхар нөлөөлж байна.

Охид ихэвчлэн зуучлагчаар дамжин худалдагддаг бөгөөд зуучлагчдын заасан газар байрладаг байна. Сүүлийн үед нэг гэр бүлийн эхнэр, нөхөр, ах дүүс зуучлагч хийх нь элбэгшиж байна. Охид хэдийгээр биеэ үнэлж байгаа ч олсон орлогоо голдуу зуучлагчдаар дамжуулан авдаг байна. Удаан хугацаагаар гадуур тэнэж байгаа болон 17-18 насны охид сүүлийн үед охид зуучлах ажилд зохион байгуулалттай оролцох болсон байна. Ялангуяа 7-8 настайгаасаа гадуур тэнэж 5, 6 жил гэрээсээ дайжин амьдарч байгаа охид амьдралын хэвшсэн дадал зуршлаасаа салах нь бүү хэл өөрсдийн туулж өнгөрүүлсэн амьдралаа шинээр гудамжинд гарч байгаа тэнэмэл хүүхдэд хүчээр тулгаж, өөрөө анх хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд нас ахих тусам өөрөө хүчирхийлэгч болон хувирч байна.

Охид хүн олноор цуглардаг, бөөгнөрөл ихтэй автобусны буудал, үзвэрийн газруудаар зогсох, зочид буудал, баар, шөнийн цэнгээний газруудаар явж үйлчлүүлэгчээ олдог байна. Охидоор үйлчлүүлэгчдийн дийлэнхийг 35 хүртэлх насныхан эзэлж байгаа бөгөөд тэд голдуу охидтой зүй бусаар харьцдаг (85% нь), ихэвчлэн ажилгүй, гэмт хэрэгт холбогдож байсан, гаж донтой, ганц бие хүмүүс байдаг байна.

Судалгаанаас харахад, өсвөр насны охид голдуу бусдын хүчинд автан биеэ үнэлж эхэлдэг байна. Охидын биеэ үнэлэх үйл ажиллагаа зөвхөн тэдний хэрэг биш, тэдэнтэй хамтардаг, тэднийг ашигладаг олон хүний зохион байгуулалттай, харилцан холбоо бүхий гурвалсан үйл ажиллагааны үндсэн дээр явагдаж байна. Энд бас нэг анхаарал татаж байгаа асуудал бол, зуучлагчид дан ганц өсвөр насны охидыг бус мөн өсвөр насны хөвгүүдийг ч дээрх үйл ажиллагаанд татан оролцуулж байгаа явдал юм.

Биеэ үнэлэгч охидын талаас илүү хувь нь 13-16 насныхан байгаа бөгөөд дийлэнх нь сургууль завсардсан охидууд, сургуульд огт хамрагдаж байгаагүй тэнэмэл охид ч цөөнгүй байна. Судалгаанаас үзэхэд биеэ үнэлдэг, ийм эрсдэлтэй охидын хувьд өөрийнхөө насанд эзэмшсэн байвал зохих боловсролын түвшин доогуур, тухайлбал, 13-14 настай охидын ердөө дөрөвний нэг нь анхан шатны, 17-18 настай охидын 10 хүрэхгүй хувь нь 8-р ангийн боловсрол эзэмшжээ. Эдгээр охидын анхан шатны боловсрол эзэмшсэн байх

нас аль хэдийн өнгөрсөн атал огт боловсролгүй охидын хувь өндөр байгаа нь албан бус сургалтанд хамрагдалтын түвшин ч доогуур байгааг харуулж байна.

Хараа хяналтгүй хүүхдийн төв байраар дамжин өнгөрч буй хүүхдүүдийн ихэнх нь арьс өнгө, бэлгийн замын халдварт өвчинтэй байна. Охид орон гэргүй, тогтсон хаяггүйгээс эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах боломжгүй байна. Эрүүл мэндийн байнгын хяналтад байдаг биеэ үнэлдэг, эрсдэлтэй охидууд бүгд бэлгийн замын халдварт өвчнөөр өвчилж байсан бөгөөд өвчнийг эмчлээд явуулсан ч богино хугацаанд дахин халдвар авдгаас эмчилгээний үр дүн гарахгүй байна.

Биеэ үнэлдэг болон ийм эрсдэлд байгаа охидын бэлгийн харьцаанд анх орсон дундаж нас 14.4 байгаа бөгөөд 8 настайдаа анх бэлгийн харьцаанд орсон охид ч цөөнгүй байна. Охидыг анх бэлгийн харьцаанд ороход давхардсан тохиолдлоор *нэгдүгээрт*: найз хөвгүүн эсвэл бусдын ятгалга (45.5%), *хоёрдугаарт*: танихгүй хүн, хойд эцэг, төрсөн эцэгтээ хүчиндүүлсэн тохиолдол (36.1%), *гуравдугаарт*: тэнэмэл, орон гэрээсээ дайжсан (18.2%), мөнгөтэй олох (16.4%) зэрэг шалтгаан голлон нөлөөлж байна.

Гэр бүлийн зөрчлийн улмаас бусдын нөлөөнд автах, эсвэл эцэг эх, ах эгч нар нь зоддог зэрэг нь охид гэрээсээ зугтан дайжих хамгийн гол шалтгаан болж байна. Бага насны охид гэр бүлийн хүчирхийлэлд, харин 17-18 насны охид бусдын нөлөө болон дарамтад илүүтэй өртснөөс орон гэрээсээ дайжиж байна. Хүчиндүүлэх, бусдад уруу татагдсан, гэр бүлийн ядуу амьдрал зэрэг нь охидыг биеэ үнэлэх гол шалтгаан болж байна.

Олон хүүхэдтэй эсвэл өрөөсгөл гэр бүлд амьдардаг охид голдуу биеэ үнэлж байна. Цаашилбал, эцэг эхийн хараа хяналт сул, анхаарал халамж муу, гэр бүлийн зөрчил их, тухайн өрх, гэрийн ая тухгүй орчин, хүүхэд хүмүүжүүлэх эцэг эхийн арга зүйн дутагдалтай байдал нь охидыг орон гэрээсээ дайжиж, улмаар биеэ үнэлэх эсвэл ийм эрсдэлтэй байдалд оруулж байна. Нөгөө талаас бүтэн эсвэл хагас өнчин охид гэр бүлийн маргааныг тэсвэрлэх чадвар сул байгаа нь магадгүй эцэг эх нь амьд байгаа хүүхэдтэй харьцуулахад тэд илүү эмзэг сэтгэхүйтэй, бусдын нөлөөнд илүү автамтгай, бусдын дарамтад илүү өртөмгийг байхад хүргэдэг байж болох юм.

Биеэ үнэлэгч охидын дийлэнх (85%) нь траншейн, орц, гудамжинд амьдарч байна. Насны бүлэг багасах тусам гудамж, траншейнээр амьдардаг охидын тоо нэмэгдэж байгаа бөгөөд айлд эсвэл гэртээ амьдардаг охидууд цөөрч байна. Тухайлбал, судалгаагаар 15-с дээш насны, биеэ үнэлдэг охидын 14-23 хувь нь айлд амьдардаг гэжээ.

Биеэ үнэлдэг болон эрсдэлийн бүлгийн охид хэрэг зөрчилд орох явдал өндөр магадлалтай бөгөөд хулгай (40%), хэв журам зөрчсөн (30%), залилан (20%)-ийн хэрэг зэрэгт голдуу холбогддог байна.

Халамжийн төвүүд нь тэнэмэл- гэгдэх хүүхдийн хувьд, нэг халамжийн төвөөс нөгөөд шилжсэн шинэ зан авир, дадал суралцах дамжлага болж байна. Энд амьдарч байгаа охид багш, эсвэл эмч нартайгаа маргалдсанаас тухайн төвийг орхиж нөгөө рүү шилждэг тохиолдол элбэг байна. Ингэснээр шинээр очсон халамжийн төвийн эрэгтэй хүүхдүүдэд хүчиндүүлдэг эсвэл бусдын дарамтанд ордог байна.

*Охид өөрсдийн хүслээр бус, арга буюу амьдрахын эрхээр болон хүчинд автан биеэ үнэлэх явдалд орж байгаа нь тэдний сэтгэл зүйд онцгой өөрчлөлтийг оруулдаг* байна. Ихэнх биеэ үнэлэгч охид өөртөө итгэх итгэл үнэмшил бага, ялангуяа анх хүчинд автан бэлгийн харьцаанд орсон болон хүчинд автан биеэ үнэлсэн охид сэтгэл зүйн гүн хямралд ордог болох нь харагдаж байна. Түүнчлэн худал ярих, хүмүүсийг хуурч мэхлэх, арга заль зохион залилах, өөрийгээ өрөвдүүлэхийн тулд худал хэлэх, бусдыг гүтгэн, доромжлох, бэлгийн гаж донтой болох зэрэг бие бялдрын болон зан харьцааны доголдол байнга ажиглагдаж байна.

Хэдийгээр биеэ үнэлэх явдалтай тэмцэх хууль эрх зүйн актууд манай улсад байгаа боловч тэдгээрийг хэрэгжүүлэх арга зам, механизм хангалтгүй байна. Охидыг зуучилж, хүчээр биеийг нь үнэлүүлж байгаа гэмт этгээдүүдэд ноогдуулж буй ял шийтгэл өнөөгийн практикт хөндөгдөж байгаа хэдий ч энэ нь гэмт хэргийг бууруулахад нөлөөлөхгүй байна. Цагдаагийн ажилтны хүн хүч, техник дутмагаас жинхэнэ зуучлагч, зохион байгуулагч нартай тэмцэх хэлбэр дутагдаж байна. Тодруулбал, хүүхдийн асуудал хариуцсан ажилтны орон тоо цөөн, гүйцэтгэх ажил үүргийн хуваарь хэт нүсэр байгаагаас садар самуун, бие үнэлэгч охидтой тулж ажиллах боломж байхгүй байна. Бусдын хүчирхийлэлд өртөж, биеэ үнэлэх замд хүчээр орж байгаа охидыг хамгаалах, тэдний цаана уг үйл ажиллагааг зохион байгуулж буй этгээдүүдтэй тулж ажиллах механизм үгүйлэгдэж байна.

Хараа хяналтгүй болон тэнэмэл хүүхдийн тоо сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж байгаа нь биеэ үнэлэгчид залуужиж, насанд хүрээгүй охидын биеэ үнэлэх үйл ажиллагаа хүрээгээ тэлж, цаашилбал охидыг хилээр дамжуулан худалдаалах үйл ажиллагаа бий болохыг үгүйсгэх аргагүй юм.

Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж буй өнөө үед хөдөлмөр эрхлэлтийн шинэ хэлбэрүүд тухайлбал, гэрийн үйлчлэгч, айлд хүүхэд асрах ажил эрхэлж буй охид, эмэгтэйчүүдийн тоо нэмэгдэх хандлагатай болж байна. Харин ийм хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүдийн насны бүтэц, цар хүрээ, тэдний ажлын нөхцөл байдал, бэлгийн хүчирхийллийн эрсдэлд орж буй эсэхийг судалсан судалгаа манайд хийгдээгүй байна. Зарим төрийн бус байгууллагуудад хандаж, зөвлөгөө авахаар ирсэн, айлд гэрийн үйлчлэгчийн ажил хийдэг охидын мэдээлж байгаагаар 16 ба түүнээс дээш насны охид айлд үйлчлэгчээр ажилладаг байна. Тэнд, охидтой ямар нэгэн гэрээ хэлэлцээр хийдэггүй, хөлс болон ажлын цагийг амаар тохирдог байна. Хөдөлмөрийн хөлсийг эд материалаар төлөх явдал нэлээд түгээмэл үзэгдэл болжээ. Мөн хөлсийг зарим үйлчлэгч охидод шууд олгохгүйгээр урьдчилсан байдлаар ар гэрийнх нь хэн нэгэнд өгчихдөг, ингэснээр өөрт наалдсан хөлсгүйгээр ажиллах тохиолдол гарч байна.

ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай 182-р Конвенцид охидын хийж буй ажлын нууцлагдмал нөхцөл байдалд анхаарлаа хандуулах, ялангуяа бэлгийн дарамт, мөлжлөгөөс хамгаалахыг заасан билээ. Энэ нь гэрийн үйлчлэгчийн ажил хийж буй насанд хүрээгүй охидын байдалд анхаарлаа хандуулахыг чухалчилж байна.

Дээр дурьдаж байсан жишээнүүдэд үндэслэн айлд гэрийн үйлчлэгчээр ажиллаж буй насанд хүрээгүй охидын байдлын талаар бүрэн дүгнэлт хийж болохгүй ч гэсэн төр захиргааны байгууллагын хяналт, олны нүднээс далд явагдаж буй хөдөлмөрийн энэ хэлбэр мөлжлөгийн хэлбэр болох эрсдэлтэй байна. Цаашилбал, ажлын хөлсийг ажиллагчид шууд олгохгүйгээр урьдчилсан

байдлаар хэн нэгэнд бөөнөөр нь олгох, ажиллагч ямар нэгэн гэрээ хийлгүйгээр ажиллаж, хөлс авахгүйгээр ахуйн хангамжаа хангуулан ажил гүйцэтгүүлэгчийнхээ эрхшээлд ямар нэг байдлаар орж байгаа болон хөлсөө бараагаар авдаг зэрэг нь Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийг зөрчиж буй хэрэг юм.

Судалгаа, шинжилгээний үр дүн дээр үндэслэн гэр бүл, олон нийт, хууль эрх зүйн хүрээнд авч хэрэгжүүлж болох дараах үйл ажиллагааны чиглэлийг зөвлөмж болгож байна. Үүнд:

1. Хараа хяналтгүй болон тэнэмэл хүүхдийн тоог бууруулахын тулд эцэг эх, асран хамгаалагчдын үүрэг хариуцлагыг дээшлүүлэх (хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, хэрэгжүүлэх);
2. Насанд хүрээгүй биеэ үнэлэгч охидтой тэмцэх үндэсний хөтөлбөр боловсруулан, хэрэгжүүлснээр биеэ үнэлэх явдлаас охидыг урьдчилан сэргийлэх, энэ явдлаас татан гаргах үйл ажиллагаанд гэр бүл, сургууль, хамт олон, олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлж, үйл ажиллагааг нэгтгэх;
3. Насанд хүрээгүй биеэ үнэлэгч охидын дунд БЗХӨ-ний тархалт, өвчлөлт маш өндөр байгааг харгалзан өсвөр үеийнхний нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрөөр дэмжуулан нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, хамрагдалтыг дээшлүүлэх;
4. Халамжийн төвүүдийн үр өгөөжийг дээшлүүлэх зорилгоор үйл ажиллагааны хяналт, үнэлэгээний механизмыг бий болгох, нэгдсэн жишиг стандартыг тогтоох;
5. Хуулийн хүрээнд охидыг зуучлагч, зуучлуулагч, тэднийг орогнуулж байгаа (зочид буудал, гэр, орон сууц, тусгай байр, тээврийн хэрэгсэл) газруудын холбогдох хүмүүстэй тооцох хууль зүйн хариуцлагыг чангатгах, үүний тулд тэдэнд ноогдуулах ялын хэмжээг бусад орнуудын ижил төстэй хууль эрхийн актыг судалсны үндсэн дээр өөрчлөн засварлах;
6. Садар самуунтай тэмцэх хуулийн хэрэгжилт, хэрэгжүүлэх арга механизм хангалтгүй байгааг харгалзан бие даасан үндэсний хөтөлбөр боловсруулан, цагдаагийн байгууллагын анхан шатны нэгжид тухайн асуудал хариуцсан боловсон хүчний орон тоог бий болгох;
7. Гэрийн үйлчлэгчийн ажилд насанд хүрээгүй охидыг татан оруулж буй байдалд судалгаа хийж, хөдөлмөрийн хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих

#### **Ном зүй:**

---

1. МУИС, ХАССТ, "Насанд хүрээгүй охидын биеэ үнэлэх явдал" судалгааны Илтгэл, 2001
2. ОУХБ, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай 182-р конвенци
3. Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль